



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 502

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймаг дахь Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 3,660,000.0 (гурван сая зургаан зуун жаран мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 1,830,000.00 (нэг сая найман зуун гучин мянган) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Булган аймаг дахь Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирал Н.Пүрэвсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001420

Төрийн эмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 1 дүгээр сарын-ны өдрийн
50х дугаар тогтоолын хавсралт

Булган аймаг дахь Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэгдэл өртөггүй, ашиглах хугацааг
сунгаж үнийг шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)			Цаашид ашиглах хугацаа (жилээр)
						Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт үнэ (төгрөг)	
1	Хүнсний ногооны мотоблок	2013.10.15	3,660,000.00	1	3,660,000.00	1,830,000.00	1	1,830,000.00	3
	Нийт дүн			1	3,660,000.0 (гурван сая зургаан зуун жаран мянган)	1,830,000.00 (нэг сая найман зуун гучин мянган)	1	1,830,000.00 (нэг сая найман зуун гучин мянган)	